

ХҮНД АЖ ҮЙЛДВЭРИЙН ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨР (2019-2023)**Нэг. Ерөнхий мэдээлэл****1.1. Хөтөлбөр боловсруулах эрх зүйн үндэслэл**

Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль, Газрын тосны бүтээгдэхүүний тухай хууль, Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хууль, Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030, Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого, Төрөөс эрдэс баялгийн талаар баримтлах бодлого, Төрөөс газрын тосны талаар баримтлах бодлого, Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Эдийн засгийг сэргээх хөтөлбөр, Гурван тулгуурт хөгжлийн бодлого, Хөгжлийн зам үндэсний хөтөлбөр болон Монгол Улсын 2018-2021 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг тус тус үндэслэн энэхүү хөтөлбөрийг боловсруулсан болно.

1.2. Нөхцөл байдал

Аж үйлдвэржилт нь технологийн өндөр багтаамжтай, нэмүү өртөг шингэсэн үйлдвэрлэлийг хөгжүүлэх, эдгээр үйлдвэрүүдийг дагасан жижиг, дунд үйлдвэрүүдийг нэмэгдүүлэх, улмаар эдийн засгийн төрөлжилтийг бий болгох замаар улс орны эдийн засагт бүтцийн шинжтэй томоохон өөрчлөлтийг бий болгогч үндсэн хүчин зүйл болж байна.

Дэлхийн улс орнууд аливаа эдийн засгийн бүтцэд зайлшгүй байх суурь салбар бол уул уурхай, түлш эрчим хүч, металлурги, хими, барилгын материал үйлдвэрлэлийн салбар гэж үзэн эдгээр салбарууд бүрдээгүй нөхцөлд эдийн засаг амжилттай хөгжих боломжгүй гэж үздэг ажээ. Дээрх салбаруудыг жигд хөгжүүлсэн орнууд санхүүгийн болон эдийн засгийн эрх чөлөөтэй болж чаджээ.

Аж үйлдвэрийн салбарыг төрийн бодлогоор дэмжин амжилттай хөгжүүлж чадсан Япон, Өмнөд Солонгос, Хятад, Тайвань, Индонези зэрэг улсууд нь дэлхийн 2 дугаар дайны дараа уламжлалт хөдөө аж ахуйд суурилсан эдийн засгийн бүтцээс аж үйлдвэржилт суурилсан эдийн засгийн бүтцэд шилжих замаар ядуурал, ажилгүйдэл, технологийн хоцрогдол зэрэг олон асуудлыг шийдвэрлэж чадсан байна. Үүнд боловсруулах үйлдвэр, тэр дундаа хүнд үйлдвэрлэлийн салбар үлэмж нөлөө үзүүлсэн байдаг.

Дэлхийн улс орнууд газарзүйн байршил, байгалийн баялагийн тархац, хүн амын тоо, түүхий эдийн хангамж зэрэг хөгжлийн үндсэн өгөгдлийн хувьд харилцан адилгүй нөхцөл, байдалд оршиж байгаа хэдий ч үйлдвэржилтийг дэмжих замаар эдийн засаг, нийгмийн баталгаагаа хангаж буй нийтлэг дүр зураг харагдаж байгаа болно. Зарим орны туршлагаас харахад хүнд аж үйлдвэрийн хөгжлийн бодлогыг дэмжих төрийн бие даасан бүтцийг бий болгож ажиллуулж иржээ. Энэтхэг, Герман зэрэг орнууд хүнд

үйлдвэрийг хөгжүүлэх тухай бие даасан хууль батлан хэрэгжүүлж байна.

Монгол улсын аж үйлдвэрийн салбарын бүтэц нь голдуу уул уурхайн түүхий эдэд тулгуурласан бөгөөд экспортын 90 гаруй хувь нь технологийн багтаамж багатай, хагас боловсруулалт хийсэн бүтээгдэхүүн эзэлж байна¹.

Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2017 оны урьдчилсан гүйцэтгэлээр 12.9 их наяд төгрөгт хүрч, өмнөх оноос 3.0 их наяд төгрөгөөр өсчээ. Үүнд уул уурхай, олборлох аж үйлдвэрийн нийт үйлдвэрлэл өмнөх оноос 2.3 их наяд төгрөгөөр, үүнээс нүүрс олборлолт 1.1 их наяд төгрөг, металлын хүдэр олборлолт 1.0 их наяд төгрөгөөр тус тус өссөн нь голлон нөлөөлжээ.

Өнөөгийн байдлаар хүнд үйлдвэрлэлийн чиглэлээр 60 гаруй аж ахуйн нэгж бүртгэгдэн үйл ажиллагаа эрхэлж байгаа бөгөөд ган туйван, ган бөмбөлөг, катодын зэс, зэс утас, цемент, машин үйлдвэрлэл, газрын тосны бүтээгдэхүүний болон метал хийцийн зарим үйлдвэрүүд бэхжиж, хэвийн үйл ажиллагааг ханган ажиллаж байгаа хэдий ч ихэнх үйлдвэрийн түүхий эд, сэлбэг, хэрэгсэл импортоос хараат, хүний нөөц дутагдалтай, борлуулалтыг дэмжих механизм бүрдээгүй, төрөөс санхүүгийн дэмжлэг үзүүлдэггүй учир эргэлтийн хөрөнгө дутагдалтай, шинэ техник, технологи, тоног төхөөрөмж нэвтрүүлэх боломж хомс, эрчим хүч, дэд бүтэц, тээвэр логистикийн нэгдсэн сүлжээ бий болоогүй зэргээс дотоодын үйлдвэрлэгчдийн бүтээгдэхүүн импортын бараатай өрсөлдөх, үйлдвэрлэл хөгжих боломж нөхцөл хязгаарлагдмал байна.

Иймд дотоодын үйлдвэрлэлийн борлуулалтыг төрөөс бодлогоор дэмжих, зах зээлийг хамгаалах, гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг татахад чиглэсэн эрх зүйн орчныг бүрдүүлэх шаардлагатай байна.

Хүнд үйлдвэрийг хөгжүүлэхэд шаардлагатай түүхий эдийн нөөц, түүний олборлолт, экспортын байдал, цаашдын хандлагыг авч үзвэл зэсийн хувьд 2017 онд Эрдэнэт үйлдвэр 640.0 мянган тонн, Оюутолгой 800.0 гаруй мянган тонн зэсийн баяжмал олборлон экспортолсон байна. Оюутолгойн ордын гүний уурхай болон Цагаансуваргын зэсийн орд ашиглалтад орсноор зэсийн баяжмалын олборлолт, экспортын хэмжээ 2 дахин нэмэгдэх төлөвтэй байна.

Монгол улсын алтны олборлолт 2012 онд 2.8 тн байснаа 2017 онд 20.0 тн болж бараг 7 дахин өсөв. Зэсийн баяжмал манай орны нийт экспортын орлогын 40 орчим хувь, алт экспортын орлогын 10 хувийг тус тус эзэлж байна. Цаашид зэсийн баяжмалын нөөцөд тулгуурлан баяжмалыг боловсруулан нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, цэвэр зэс экспортлогч орон болох боломж байна.

Төмрийн баяжмалын үйлдвэрлэл 2017 онд 6.3 сая.тонн байсан бол 2022 онд 7.7 сая.тонн болж өсөх төлөвтэй байна. Түүнчлэн манай улсын хувьд уул уурхай болон барилгын салбарын үйлдвэрлэл эрчимтэй өсч байгаагаас дотоодын төмрийн хэрэгцээ өсөн нэмэгдэж байна. Цаашид төмрийн хүдрийн нөөцөд тулгуурлан

¹ <https://mrpam.gov.mn/article/90/>

дотоодын хэрэгцээг хангах зорилгоор гангийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх боломж байна.

Манай улсын шатахууны хангамж гадаад эх үүсвэрээс бүрэн хамааралтай байгаа өнөө үед газрын тосны дэлхийн зах зээлийн үнийн хэлбэлзэл, нийлүүлэлт, валютын ханшны өөрчлөлтөөс шалтгаалан шатахууны хомсдол үүсэх магадлалтай бөгөөд энэ нь манай улсын эдийн засгийн тогтвортой байдалд сөргөөр нөлөөлөх хандлагатай байдаг тул газрын тосны үйлдвэрийг барьж дотоодын хэрэгцээгээ хангах, ингэхдээ Тосон уул, Тамсаг болон Цагаан элсийн ордуудын түүхий газрын тосыг боловсруулж автобензин, дизель түлш, онгоцны түлш, шингэрүүлсэн шатдаг хий болон бусад дагалдах химийн бүтээгдэхүүн үйлдвэрлэхээр төлөвлөж байна.

Нүүрсний хувьд улсын хэмжээнд 2017 онд нийт 171 аж ахуйн нэгж ашиглалтын 296 тусгай зөвшөөрөл эзэмшиж байна. Манай улс хүрэн нүүрсний арвин нөөцтэй, 2017 оны байдлаар геологийн нөөц 173 тэрбум.тн, үүнээс ашиглалтын 37.4 тэрбум.тн-ын нөөц бүртгэгдээд байна. Нүүрсний арвин нөөцөд тулгуурлан нүүрсийг гүн боловсруулах, нүүрснээс байгалийн хий үйлдвэрлэх боломжтой бөгөөд энэ чиглэлээр томоохон төслүүд хэрэгжихээр бэлтгэл хангагдаж байна.

1.3. Тулгамдаж байгаа асуудал

Манай улсын хүнд аж үйлдвэрийн хууль эрх зүйн болон татварын орчин, бүтээгдэхүүний үйлдвэрлэл болон экспортод дараахь асуудлууд тулгамдаж байна. Үүнд:

1.3.1. Хүнд аж үйлдвэрийн томоохон төслүүдийг хэрэгжүүлэх, шинэ үйлдвэрүүдийг барьж байгуулах нь өндөр зардалтай, хөрөнгө оруулалтаа нөхөх хугацаа урт байдаг тул энэхүү салбарт гадаадын шууд хөрөнгө оруулалтыг татах болон гадаадын хөнгөлөлттэй зээлд хамааруулах зорилгоор Засгийн газраас санхүүгийн баталгаа шаардлагатай байна.

1.3.2. Одоогийн үйл ажиллагаа эрхэлж буй хүнд үйлдвэрүүдийн хүчин чадал ашиглалт хангалтгүй, дотоодын зах зээлийг хамгаалах, дэмпингийн чанартай импортын эсрэг зохицуулалтын механизм бий болоогүй байна.

1.3.3. Монгол Улсын хүнд аж үйлдвэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл болон экспортын тээвэр ложистикийн дэд бүтэц бий болоогүй байна.

1.3.4. Хүнд аж үйлдвэрт шаардлагатай боловсон хүчнийг бэлтгэх, давтан сургах, мэргэшүүлэх сургалтыг зохион байгуулах шаардлагатай байна.

1.3.5. Хүнд аж үйлдвэрийн томоохон төслүүдийг хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа суурьшлын бүсүүдэд хөрөнгө оруулалтыг татах, тэдгээрийн дэд бүтцийн барилга байгууламжуудыг барьж байгуулахад төрөөс татварын болон санхүүгийн дэмжлэг үзүүлэх шаардлагатай.

1.3.6. Монгол Улсын хүнд аж үйлдвэрийн бүтээгдэхүүний экспортын худалдааны тарифын болон тарифын бус хориг саадыг багасгах арга хэмжээг хэрэгжүүлэх

шаардлагатай.

Иймд Хүнд аж үйлдвэрлэлийн салбарт тулгарч буй хүндрэл бэрхшээлийг шийдвэрлэх, тус салбарт хөрөнгө оруулалт татах, нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлэх зорилгоор хүнд аж үйлдвэрлэлийн үндсэн түүхий эд болох зэс, алт, төмрийн баяжмал, нүүрс болон газрын түүхий тосны нөөц, үйлдвэрлэл, экспорт болон импортын худалдааны өнөөгийн нөхцөл байдлын үнэлгээ, хүнд аж үйлдвэрийн нийгэм-эдийн засаг болон байгаль орчинд нөлөөлөх нөлөөллийн үнэлгээнд тулгуурлан, үйлдвэржилтийн зураглалтай уялдуулан энэхүү хөтөлбөрийг боловсруулсан болно.

1.4. Хамрах хүрээ

Хүнд аж үйлдвэрт эхний ээлжинд металлург, газрын тос, нүүрс болон нүүрс химийн боловсруулах үйлдвэрүүдийг хамруулах бөгөөд цаашид уран, цайр, жонш болон бусад төрлийн эрдсийг боловсруулах үйлдвэрлэлийг үе шаттайгаар байгуулж хөгжүүлэх бэлтгэлийг хангана.

Хоёр. Хөтөлбөрийн зорилго, зорилт

2.1. Хөтөлбөрийн зорилго

Монгол Улсын эдийн засгийн суурь бүтцийг бүрдүүлэх зорилгоор металлурги, газрын тос, нүүрс болон нүүрс химийн боловсруулах үйлдвэрүүдийг байгуулж хөгжүүлэх, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, байгаль орчинд ээлтэй, дэвшилтэт техник технологийг нэвтрүүлэн нутагшуулах, ажлын байрыг нэмэгдүүлэх, улмаар хүнд үйлдвэрийн салбарын эдийн засагт оруулах үр өгөөжийг дээшлүүлэхэд энэхүү хөтөлбөрийн зорилго оршино.

2.2. Энэхүү хөтөлбөрийн зорилгыг хангахын тулд дараах зорилтуудыг дэвшүүлж хэрэгжүүлнэ:

2.2.1. Хүнд аж үйлдвэрийн хууль эрх зүй, хөрөнгө оруулалт болон татварын таатай, тогтвортой орчинг бий болгох;

2.2.2. Өнгөт төмөрлөгийн үйлдвэрлэлийг хөгжүүлж, зэсийн баяжмал боловсруулах болон алт цэвэршүүлэх үйлдвэрийг байгуулах бэлтгэлийг хангаж, үйлдвэрийн барилгыг дуусгах;

2.2.3. Хар төмөрлөгийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх;

2.2.4. Нүүрс болон нүүрс химийн боловсруулах үйлдвэрлэлийг хөгжүүлэх;

2.2.5. Газрын тос боловсруулах үйлдвэрийг дагалдах үйлдвэрүүдийн хамт байгуулж, хөгжүүлэх;

2.3.6. Үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, метал

хийц, машин үйлдвэрлэлийг хөгжүүлэх

Гурав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээ

3. Хөтөлбөрийн хүрээнд дараахь арга хэмжээг хэрэгжүүлнэ:

3.1. Хөтөлбөрийн 2.2.1-д заасан зорилтын хүрээнд:

3.1.1. Хүнд аж үйлдвэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, экспортын худалдаанд оролцож байгаа салбарууд, яамд, төрийн бусад байгууллагын үйл ажиллагааг уялдуулах, хүнд аж үйлдвэрлэл-худалдаа-хөрөнгө оруулалтын цогц бодлогыг дэмжихэд чиглэсэн “Хүнд аж үйлдвэрийг дэмжих тухай хууль”-ийн төслийг боловсруулж батлуулах арга хэмжээ авах;

3.1.2. Хүнд аж үйлдвэрийн салбарын боловсруулалтын түвшинг ахиулах, үйлдвэрлэл, экспортыг дэмжих зорилгоор Үйлдвэрлэлийг дэмжих тухай хууль, Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хууль, Хөрөнгө оруулалтын тухай хууль болон Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах;

3.1.3. Хүнд үйлдвэрийг барьж байгуулах болон үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд шаардлагатай технологийн тоног төхөөрөмж, дотоодод үйлдвэрлэдэггүй түүхий эдийн жагсаалтыг гаргаж, гааль болон НӨАТ-аас чөлөөлөх тухай хуулийн төсөл боловсруулж батлуулах;

3.1.4. Хүнд үйлдвэрийн томоохон төслүүдийг барьж байгуулахад шаардлагатай хөрөнгө оруулалтыг татахад төрөөс баталгаа гаргах, зарим тохиолдолд төр хувь эзэмших замаар дэмжлэг үзүүлэх;

3.1.5. Хүнд үйлдвэрийн салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллагуудад эргэлтийн хөрөнгийн бага хүүтэй зээлийн эх үүсвэрийг шийдвэрлэх зорилгоор дотоод, гадаадын санхүүгийн байгууллагуудтай хамтран ажиллаж шийдвэрлэх арга хэмжээ авах;

3.1.6. Хүнд үйлдвэрийн салбарыг бүтээгдэхүүний зах зээл, эрэлт хэрэгцээ, түүхий эдийн нөөцтэй уялдуулж хөгжүүлэх чиглэлээр холбогдох судалгааг хийх, энэ чиглэлээр гадаадын хөгжлийн байгууллагуудтай хамтран ажиллах;

3.1.7. Хөрш орнуудтай байгуулсан худалдаа, эдийн засгийн хэлэлцээрүүдэд хүнд аж үйлдвэрийн бүтээгдэхүүний экспортын худалдааны тарифын болон тарифын бус хориг саадыг багасгах арга хэмжээг тусган хэрэгжүүлэх;

3.1.8. Импортыг орлох бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлэх, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх чиглэлээр салбарын аж ахуйн нэгжүүдэд төрөөс дотоодын үйлдвэрлэлийн худалдан авалтыг бодлогоор дэмжих, дотоодын зах зээлийг хамгаалах, тарифын зохицуулалт хийх замаар дэмжлэг үзүүлэх;

3.1.9. Уул уурхай, хүнд үйлдвэрийн хөгжлийг дэмжих, чадавхыг дээшлүүлэх

чиглэлээр ажиллаж буй олон улсын хөгжлийн байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулах, тэдгээрийн хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрт хүнд аж үйлдвэрийн хөгжлийн хөтөлбөрийн арга хэмжээнүүдийг тусган хэрэгжүүлэх, хамтран ажиллах;

3.1.10. Хүнд үйлдвэрийн салбарын аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааг дэмжсэн даатгалын тогтолцоог бий болгох;

3.2. Хөтөлбөрийн 2.2.2-т заасан зорилтын хүрээнд:

3.2.1. Эрдэнэт болон Оюу толгой ордыг түшиглэн зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр байгуулах бэлтгэлийг хангаж, зэс экспортлогч орон болох үндэс суурийг тавих;

3.2.2. Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэрээс гарах хүхэр болон бусад дайвар бүтээгдэхүүнийг боловсруулах үйлдвэрийг байгуулахад дэмжлэг үзүүлэх, байгаль орчны сөрөг нөлөөг багасгах техник технологийн оновчтой шийдлийг сонгож, хэрэгжүүлэх;

3.2.3. Хүхрийн хүчлийг тээвэрлэх, экспортын зах зээлд хүргэх тээвэр-ложистикийн сүлжээ байгуулах;

3.2.4. Эрдэнэтэд Sx/Ew уусган баяжуулах шинэ хүчин чадлуудыг ашиглалтад оруулах замаар өнөөгийн цэвэр зэсийн үйлдвэрлэлийг тогтвортой нэмэгдүүлэх;

3.2.5. Зэс утас үйлдвэрлэх хүчин чадлыг нэмэгдүүлж, бүтээгдэхүүнийг дотоодын болон дэлхийн зах зээлд борлуулахад дэмжлэг үзүүлэх;

3.2.6. Алт цэвэршүүлэх үндэсний үйлдвэр байгуулахад дэмжлэг үзүүлэх;

3.2.7. Зэсийн баяжмал боловсруулах болон алт цэвэршүүлэх үндэсний үйлдвэрийг байгуулахад төр ба хувийн хэвшлийн хамтын ажиллагааг өргөжүүлэх;

3.3. Хөтөлбөрийн 2.3.3-т зорилтын хүрээнд:

3.3.1. Ган бүтээгдэхүүний дотоодын хэрэгцээг хангах зорилгоор үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, төмрийн хүдрийн баяжмалын экспортын хэмжээг үе шаттайгаар хязгаарлах;

3.3.2. Төмрийн хүдрийн баяжуулах болон гангийн үйлдвэрүүдийн хүчин чадлын ашиглалтыг сайжруулах, техник технологийн түвшинг дээшлүүлэх арга хэмжээ авах;

3.3.3. Ган туйван, ган бөмбөлөг зэрэг үндсэн нэр төрлийн бүтээгдэхүүний хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлээр хангах;

3.3.4. Орхон болон “Дархан-Сэлэнгийн бүсэд хар төмөрлөгийн цогцолборыг дэд бүтцийн хамт байгуулах төсөл”-ийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

3.3.5. Металлургийн кокс, төмөрлөгийн үйлдвэрийн цогцолборыг байгуулахад

дэмжлэг үзүүлэх;

3.4. Хөтөлбөрийн 2.2.4-д заасан хүрээнд:

3.4.1. Гадаад зах зээлийн импортын хэрэгцээ, монгол орны дэд бүтцийн дамжин өнгөрүүлэх чадвар, зах зээлийн эрсдэл, хөрөнгө оруулалтын өгөөж зэрэг хүчин зүйлүүдийг харгалзан нүүрсний салбарын үйлдвэрлэл, экспортын хэмжээг 60,0 сая.тн-д хүргэж, бүс нутгийн нүүрсний томоохон экспортлогч орон болох нөхцлийг бүрдүүлэх;

3.4.2. Таван толгойн нүүрсний олборлолт, боловсруулалтыг экспортод чиглэсэн иж бүрэн чиглэлээр хөгжүүлэх;

3.4.3. Говийн бүсэд кокс химийн үйлдвэрийг зах зээлийн эрэлт хэрэгцээнд үндэслэн хөгжүүлэх арга хэмжээг авах;

3.4.4. Таван толгойн ордыг түшиглэн нүүрс-химийн үйлдвэрийг барьж байгуулах суурь нөхцөлийг бүрдүүлнэ.

3.4.5. Нялга-Чойрын нүүрсний ордуудыг түшиглэн нүүрс хийжүүлэх үйлдвэрийг барьж байгуулахад дэмжлэг үзүүлэх;

3.4.6. Хүнд үйлдвэрийн дэд бүтцийн бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалт, бүтээгдэхүүний борлуулалтын талаар хөрш орнуудтай хэлэлцээ хийж, үйлдвэрлэлийн хүчин чадлыг уялдуулах арга хэмжээ авах;

3.5. Хөтөлбөрийн 2.2.5-д заасан зорилтын хүрээнд:

3.5.1. Дорноговь аймагт газрын тос боловсруулж, авто бензин, дизель түлш зэрэг бүтээгдэхүүн үйлдвэрлэх үйлдвэрийг барьж байгуулах;

3.5.2. Газрын тосоор тогтвортой хангах, нөөц нэмэгдүүлэхэд чиглэсэн ашиглалтын үеийн хайгуулын ажлыг эрчимжүүлэх;

3.5.3. Газрын тосны бүтээгдэхүүний бага оврын үйлдвэрүүдийг бодлогоор дэмжинэ.

3.6. Хөтөлбөрийн 2.2.6-д заасан зорилтын хүрээнд:

3.6.1. “Засвар механикийн үйлдвэр”-ийн хүчин чадлыг өргөтгөх, бүтээгдэхүүний нэр төрлийг төрөлжүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх;

3.6.2. Металл хийц, машин үйлдвэрлэлийг бодлогоор дэмжиж хөгжүүлэх;

3.6.3. Хүнд үйлдвэрийн чиглэлийн үйлдвэрлэл, технологийн паркуудыг байгуулж, кластераар хөгжүүлэх ажлыг эрчимжүүлэх;

3.6.4. Хүнд аж үйлдвэрийн хүний нөөцийг бэлтгэх, сургах, чадавхижуулах, бодлого, хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлэх;

3.6.5. Хүнд аж үйлдвэрийн бүтээгдэхүүний сорилтын лабораторийн чадавхийг нэмэгдүүлэх;

3.6.6. Хүнд үйлдвэрийг парк, кластераар хөгжүүлэх боломжийг бүрдүүлэх зорилгоор шаардлагатай дэд бүтэц, тээвэр ложистикийн нэгдсэн сүлжээг бий болгох, эрчим хүчээр тасралтгүй хангахад дэмжлэг үзүүлэх;

Дөрөв. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа, үе шат, хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлт

4.1. Хөтөлбөрийг 2019-2023 онд 5 жилийн хугацаанд хэрэгжүүлнэ.

Тав. Хөтөлбөрийн үр нөлөө, бүтээгдэхүүн, шалгуур үзүүлэлт

5.1. Хөтөлбөр хэрэгжсэнээр дараахь үр дүнд хүрнэ. Үүнд:

5.1.1. Цэвэр зэс үйлдвэрлэл 1,6 дахин, зэс утасны үйлдвэрлэл 2 дахин нэмэгдэнэ. Ган бөмбөлөг, ган туйван зэрэг үндсэн нэр төрлийн ган бүтээгдэхүүний дотоодын хэрэгцээг хангана.

5.1.2. Шинэ үйлдвэрүүд нэмэгдэж, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэл өсч, эдийн засгийн бүтцэд өөрчлөлт орно.

5.1.3. Газрын тос боловсруулах үйлдвэр ашиглалтад орсноор газрын тосны бүтээгдэхүүн автобензин, дизель түлшний импорт 1.0 гаруй тэрбум ам.доллараар буурч, энэ хэмжээгээр гадаад худалдааны тэнцлийн орлого нэмэгдэнэ.

5.1.4. Хүнд аж үйлдвэрийн салбараас улсын болон орон нутгийн төсөвт орох орлого нэмэгдэж, бүс нутгийн хөгжлийг түргэтгэхэд жинтэй хувь нэмэр оруулна.

5.1.5. Ажлын байр тогтвортой өсч, 5000 гаруй ажлын байр шинээр бий болно.

5.1.6. Хүнд аж үйлдвэрийн үйлдвэрлэл, экспортын худалдааны хууль эрх зүй, хөрөнгө оруулалт, татвар, санхүүгийн тогтвортой, таатай орчинг бүрдүүлнэ.

Зургаа. Хөтөлбөрийн санхүүжилт

6.1. Хөтөлбөрийн санхүүжилтийг дараах эх үүсвэрээс бүрдүүлнэ. Үүнд:

- Улсын төсөв
- Хөгжлийн банк;
- Хөгжлийн түнш байгууллагуудын хөнгөлөлттэй зээл, тусламж;
- Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт;
- Төр хувийн хэвшлийн түншлэл;

-Бусад эх үүсвэр.

Долоо. Хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээний төлөвлөгөө

7.1. Уул уурхай, хүнд үйлдвэрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад жил бүр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, тайланг дараа оны 1 дүгээр улиралд багтаан Засгийн газарт танилцуулна..

7.2. “Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журам”-ын 60.2-д заасны дагуу “хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн, санал зөвлөмжийг хэрэгжүүлэхтэй холбогдсон үйл ажиллагааг холбогдох төрийн байгууллагууд хэрэгжүүлнэ.

7.3.Хөтөлбөрийн дараах шалгуур үзүүлэлтийн дагуу хяналт-шинжилгээ хийж үнэлнэ.

№	Шалгуур үзүүлэлт	Нэгж	Суурь түвшин, он	Зорилтот түвшин, он	Мэдээллийн эх сурвалж	Хариуцагч байгууллага
			2018	2023		
1	Катодын зэс/99,99%	мян.т н	15	25	“Монгол Улсын хүнд аж үйлдвэрийн хөгжлийн бодлогын нөхцөл байдлын дүн шинжилгээ”- 2018	УУХҮЯ, ГХЯ
2	Зэс кабель утас	тн	200	500	“Монгол Улсын хүнд аж үйлдвэрийн хөгжлийн бодлогын нөхцөл байдлын дүн шинжилгээ”- 2018	УУХҮЯ, ГХЯ

3	Хайлуулж цэвэршүүлсэн алт	тн	20	25	“Монгол Улсын хүнд аж үйлдвэрийн хөгжлийн бодлогын нөхцөл байдлын дүн шинжилгээ”- 2018	УУХҮЯ, ГХЯ
---	---------------------------------	----	----	----	---	------------